

“МОНГОЛ БА ИХ ГҮРНҮҮД ХХ ЗУУНЫ ЭХНИЙ ХАГАСТ” СТАЛИН, ЧАН КАЙШИ, МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ СЭДЭВТ СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ТУХАЙД

*К.Дэмбэрэл**

Их Монгол улсыг байгуулсны 800 жилийн ойд Монголын судлаачдын барьсан томоохон бүтээлийн нэг бол түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Батбаярын “Монгол ба Их гүрнүүд ХХ зууны эхний хагаст” Сталин, Чан Кайши, Монголын тусгаар тогтнол сэдэвт судалгааны бүтээл зүй ёсоор орно.

Монголын түүхийн нэлээд “ээдрээтэй” үе болох ХХ зууны эхэн хагасын үеийн гадаад орчин, түүний хувьсал өөрчлөлтийн талаар бодит эх сурвалжууд, архивын баримтуудыг монгол, орос, англи, япон, хятад хэлнээс харьцангуй бүрэн дүүрэн ашиглан туурвисан энэхүү судалгааны бүтээл нь 8 бүлэг, удиртгал бүлэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсэгтэй, 28.75 хх хуудастайгаар уншигчдын хүртээл боллоо.

2002 онд доктор, профессор Ц.Батбаяр нь “ХХ зууны эхэн хагасын Монгол, Японы харилцаа” нэгэн сэдэвт судалгааны зохиолыг орос хэлээр хэвлүүлсэн билээ.

“Монгол ба Их гүрнүүд ХХ зууны эхний хагаст” бүтээлийг түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Дашдаваа хянан ариутгасан.

Монголын нийгмийн бүхий л амьдрал үзэл суртал, хүчтэй цензураас ангид бичигдэх болсон үеэс судалгааны томоохон бүтээл олныг туурвиж буй дунд үеийн судлаачдын нэг нь доктор, профессор Цэдэндамбын Батбаяр юм. Олон улсын харилцааны түүх, орчин үеийн олон улсын харилцаа болон дорно дахины асуудлаар бичсэн ном зохиолууд, олон тооны өгүүлэл нийтлэлүүд нь түүнийг авьяаслаг, нөр их хөдөлмөрч, эрдэмтэн хүн гэдгийг харуулж байна. Энэ бүтээлдээ зохиогч маань олон орны архивын материал, олон хэл дээрхи судалгааны зохиолуудыг өргөн ашиглаж олон асуудлаар түүнд харьцуулсан дүгнэлт хийх өргөн боломжийг нээж өгсөн.

Хэдийгээр зохиолын Удиртгал бүлэг нь “Азийн эх газрын талаархи Их Гүрнүүдийн бодлого” гэсэн гарчигтай ч энд Хаант Орос, Манж Чин, Япон улсуудын зүгээс Зүүн Азид явуулж байсан бодлогыг голлон анхаарчээ. Мөн энэ бүлэгт “Хаант Орос, Япон улсууд нь Манжуур, Монголд нөлөөний хүрээний асуудлаар үндсэндээ тохирсон” гэсэн дүгнэлт хийсэн.

“Тусгаар тогтнолын мөрөөдөл” /1911-1919/ гэсэн нэгдүгээр бүлэгт 1911-1912 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн,

* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Их гүрнүүдийн байр суурь, Монгол-Оросын 1912 оны гэрээ, Хиагтын 1915 оны гэрээ, Монголын автономыг устгасан гэсэн асуудлыг хамруулсан нь энэ үед чухамхүү монголчууд тусгаар тогтнол, эрх чөлөө, бүхэн эрхт байдлынхаа төлөө ихээхэн хүчин чармайлт гарган тэмцэл өрнүүлсэн тухайг судалжээ.

“Зөвлөлт-Хятадын хэлэлцээ ба Монголын статус” /1920-1924/ хэмээх хоёрдугаар бүлэг нь Октябрийн хувьсгалын дараахи Алс Дорнодын улс төрийн байдал, Японы бодлого үйл ажиллагаа, Зөвлөлт Орос ба 1921 оны Монголын хувьсгал, Монголын асуудлаархи төв Хятадын байр суурь, 1920-1924 оны Зөвлөлт-Хятадын хэлэлцээрүүдийг тодруулан шинжилжээ. Тухайлбал, зохиолд бичснээр Б.З.Шумяцкий Монголд хийсэн ажлын тайландаа “...Бид манай хилийн хамгийн эмзэг газар болсон Сэлэнгэ мөрний сав, Жид, Дархад хүрээ, Кошагач дагуух мянган бээрийн хил хязгаарыг хааж бөглөсөн эрх чөлөөт Монгол улс гэсэн холбоотонтой боллоо” хэмээн дүгнэжээ.

“Коминтерн, МАХН ба Хятадын хувьсгал” /1925-1928/ хэмээх гуравдугаар бүлэгт Коминтерн, МАХН, Гоминдан, Танакагийн меморандум, Монголын гадаад бодлого, үндэсний үзлийн зарим асуудлыг хамруулан судалсан байна. Энд МАХН-аас Коминтерн болон Гоминдантай хэрхэн харилцаж эхэлснийг тодруулсан.

“Монголын талаархи Сталины геополитик” /1932-1936/ гэсэн дөрөвдүгээр бүлэгт Манжго байгуулагдсан, Зөвлөлт-Японы харилцаа хурцадсан нь, Монголын талаархи Зөвлөлтийн геополитик, Манжуурын бага хурал, Сталин Гэндэний хэлэлцээ, 1936 оны гэрээ гэсэн Зөвлөлтийн зүгээс Монголын талаархи геополитикийг идэвхжүүлсэн асуудлыг хөндсөн байна.

“Халх голын дайн ба Их гүрнүүд” /1937-1939/ хэмээх тавдугаар бүлэгт БНМАУ-ын геостратегийн ач холбогдол өссөн нь, Зөвлөлтийн цэрэг Монголд орсон нь, Зөвлөлт-Японы сөргөлдөөн, Зөвлөлт-Германы үл довтолх гэрээ, Халх голд гал зогсоосон нь, 4 талын хилийн хэлэлцээр зэрэг дэлхийн 2-р дайны өмнөх Монголын гадаад орчинг шинжилжээ.

“Зөвлөлт-Японы төвийг сахих гэрээ ба БНМАУ-ын асуудал” /1941-1943/ гэсэн зургадугаар бүлэгт ерөнхийдөө Зөвлөлт, Японы харилцаа болон түүнд Монголын асуудлыг хэрхэн авч үзэж байсныг зохиолд судлан бичжээ.

“Чан Кайши, Гоминданы Хятад БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн нь” /1945-1946/ хэмээх долдугаар бүлэгт БНМАУ-ын баруун хилийн асуудал, АНУ-ын дэд ерөнхийлөгч Монголд айлчилсан нь, Каир, Ялтын бага хурал, түүний шийдвэрүүд, Чан Кайши

ба Монголын асуудал, БНМАУ Японд дайн зарласан нь, Гоминданы Хятад БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн нь гэсэн асуудлыг судлан нягталжээ. Энэ үед БНМАУ-ын статус-кво-г хэвээр хадгалахын төлөө Зөвлөлтийн удирдлагын байр суурь нэлээд хатуу байсныг Сталин, Чан Кайшигийн төлөөлөгчдийн хооронд болсон яриаг зохиолд иш татсан байна. Тухайлбал, Сталин хэлэхдээ: “Монголчууд Гадаад, Дотоод Монголыг нэгтгэхийг маш их хүсэж байгаа юм. ...Тэдний энэ мөрөөдлийг нь орхигдуулахын тулд Гадаад Монголыг даруйхан хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Хэрвээ тэд Дотоод Монголыг нэгтгэхийг хүсвэл дайн болно гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Орос өөрийн зүгээс тэднийг хил хязгаараа өргөтгөхөд туслалцаа үзүүлэхгүй” гэжээ.

Төгсгөлийн буюу наймдугаар бүлгийг **“Мао Зэдун, ХКН БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн нь”/1946-1950/** томъёолж БНМАУ НҮБ-д элсэх хүсэлтээ гаргасан нь, Микоян Хятадад, Сталин Чойбалсан нарын сүүлчийн уулзалт, БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтсон нь зэрэг гурван улсын шинэ үеийн харилцааны эхэн үеийн асуудлыг хөндсөн байна.

Энэ бүтээлд Монгол Улс, ОХУ, Япон улс, БНХАУ, АНУ-ын архивын 50 гаруй материал, 5 хэлээр хэвлэгдсэн архивын баримт бичгийн эмхэтгэл 20 гаруй, судалгааны зохиолын хувьд монгол хэлээр 90, орос хэлээр 63, хятад хэлээр 27, япон хэлээр 46, өрнөдийн хэлээр 50 бүтээлүүдийг ашиглажээ.

Дүгнэлт

“Монгол ба Их гүрнүүд ХХ зууны эхний хагаст” Сталин, Чан Кайши, Монголын тусгаар тогтнол сэдэвт судалгааны бүтээлийн бүлэг бүрт Монгол-Оросын, Монгол-Зөвлөлтийн харилцааны асуудлыг хөндөж бичсэн тул бүтээлийг бүхэлд нь хоёр орны харилцааны түүхийн томоохон бүтээл хэмээн үнэлэх нь зүйтэй. Энэ бүтээлийн чухал ач холбогдлын нэг бол Монгол Улсын геостратегийн байрлал нь түүний түүхэнд хэрхэн нөлөөтэй байсныг тодорхойлсон явдал.

Монголын түүхийн түвэгтэй үеийн гол асуудал болох хөгжлийн гадаад хүчин зүйлийн түүхэн үнэнийг нь тодруулахад хүчин зүтгэж түүхийн судалгаанд дорвитой хувь нэмрээ доктор, профессор Ц.Батбаяр нэгэнт оруулжээ.